



Монгол Улсын Их сургууль
Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын
Сургууль

Resilience in Public Administration

Бэлтгэсэн ТУ-IV түвшин:

Д.Энхжин

И. Марал-Эрдэнэ

Б.Ичинноров

2019.11.29



Агуулга

2

Resilience in Public Administration нэр томъёог судлах шаардлага

Resilience нэр томъёоны тайлбар

Resilience in Public Administration нэр томъёоны тайлбар

Resilience in Public Administration хөгжүүлэх шаардлага

Resilience in Public Administration нэр томъёог хэрэгжүүлсэн Австрали улсын төрийн байгууллагын жишээ

Дүгнэлт

Ашигласан материал



Resilience in Public Administration нэр томъёог судлах шаардлага

3

Дэлхийн хүн ам хурдтай өсөн нэмэгдэж нийтийн шинжтэй олон асуудлыг шийдвэрлэх шаардлага урган гарч иргэдийн амь нас, өмчийг хамгаалах, чухал нөөцүүдээр байнга хангах, эдийн засгийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, мөн цаашлан шинжлэх ухаан технологийн дэвшлийг хангах төдийгүй байгаль орчныг хамгаалах асуудлуудыг зохицуулахын тулд Public administration буюу Нийтийн удирдлагын үүрэг роль өсөн нэмэгдэн илүү шинжлэх ухаанчаар хөгжихийг шаардсан.



Resilience -орчуулга


4

- Англи-монгол толь бичигт/болор толь/: Уян хатан байдал
- Англи-англи толь бичигт/Cambridge/: the **ability** to be **happy**, **successful**, etc. again after something **difficult** or **bad** has **happened**
- “Тогтвортой байдал буюу эрсдэл, өөрчлөлт, бэрхшээлийг даван туулах, дасан зохицох чадвар”



Resilience нэр томъёоны хэрэглэгдэх байдал

5





“Resilience in Public Administration”

6

“Төрийн удирдлагын үйл ажиллагааны уян хатан байдал мөн дасан зохицох буюу эрсдэлийг даван туулах чадвар болоод тэнцвэрэй байх цогц чадамж”



Resilience in Public Administration

Resilience in public administration буюу төрийн удирдлагын үйл ажиллагааны цогц чадамжийг бий болгохын тулд албан хаагчид руу чиглэсэн үйл ажиллагануудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Дараах тохиолдолд:

- Их ажлын цаг, ажлын ачаалал,
- Ажлын байрны тогтворгүй байдал,
- Зөрчилдөөн,
- Нийгмийн дэмжлэг, баталгаа бага байх зэрэг нь



Resilience in Public Administration хөгжүүлэх шаардлага

8

- Анх 2000-аад оны үед төрийн удирдлагад нөлөөлсөн томоохон гэнэтийн эрсдэлтэй болоод тодорхойгүй байдалд бэлэн байж хариу арга хэмжээ, шинэ стратеги хэрэгтэй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрсөн юм.
- Энэхүү жишээгээр төрийн удирдлагын байгууллагууд аливаа олон нийтийн шинжтэй эрсдэлээс урьдчилан сэргийлж, зайлшгүй нөхцөлд бэлэн байж, хохирол гарсан тохиолдолд даруй арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэн уян хатан үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэдгийг сануулсан юм



“Australian Government Comcare”

- Австралийн холбооны Засгийн газрын харьяа байгууллага бөгөөд боловсрол, хөдөлмөр эрхлэлт хийгээд эрүүл аюулгүй ажлын байр бий болгох хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилладаг байгууллага.
- Үндсэн чиг үүрэг нь: эрүүл аюулгүй ажлын байраар дамжуулан ажилчдын оролцоо, бүтээмжийг нэмэгдүүлэх явдал юм.



“Working well” хөтөлбөр

10

2008 онд “Working well” хөтөлбөр: байгууллагын хэмжээнд стресс болон сэтгэл зүйн дарамтаас урьдчилан сэргийлэх тухай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ нь 4 зүйл дээр анхаарал хандуулан ажилласан . Үүнд:

1. Байгууллагын зөв зохион байгуулалтын бүтэц, загварыг бий болгосон бөгөөд манлайлал болон удирдлагын хэв маягийг өөрчилсөн.
2. Хамтын ажиллагааны орчин бүрдүүлсэн ба энэ нь байгууллагын үнэ цэнийг болгож, албан хаагчдын санал хүсэлтийг хүлээн авч, зорилгоо нэгтгэн, ажлын чиг үүргийн тодорхой болгосноор албан хаагчдын оролцоо болоод шийдвэр гаргах боломж, чадвар нэмэгдсэн.
3. Албан хаагчдын сэтгэл ханамж дээр анхаарлаа хандуулснаар ажилчдын сэтгэл зовоосон асуудал буурсан ба үүнийгээ дагаад стресс буурсан.
4. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл болоод зан төлөв дээр анхаарлаа хандуулснаар ажлын гүйцэтгэл сайжирч улмаар ажилдаа хандах хандлага нэмэгдсэн байна.



“Working well” хөтөлбөр-хэрэгжүүлсэн үе шат

11



Эрсдэлийг тогтоох

Байгууллагын ажиллагсдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд учирч болзошгүй хүчин зүйлсийг тогтоох /хамт олны таагүй уур амьсгал, зөрчилдөөн гэх мэт/



Эрсдэлийг үнэлэх

Гарч болох эрсдэлийг системтэйгээр үнэлэн, мөн ажлын байран дахь сэтгэл зүйн дарамт, түүний цар хүрээ шалтгааныг тодорхойлохын тулд байгууллага доторх стресс үүсгэж буй эх үүсвэрийг олж, тэдгээрт дүн шинжилгээ хийх.



Төлөвлөгөө гаргах:

Сэтгэлзүйн дарамт цаашлаад сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар албан хаагч болон удирдлагууд хэлэлцэн судалгаа хийж, байгууллагад тохирох аргыг сонгох. Мөн албан хаагчдыг стресст орсныг мэдсэн даруйдаа хариу арга хэмжээ үзүүлэх, хүндрэхээс нь өмнө шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байх.



Хяналт шалгалт хийх:

Хэрэгжилт болон үр нөлөөг нь хянах, мөн түүнчлэн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нь тодорхойлон зорилгодоо хүрсэн эсэхийг хэмжих. Үүнийгээ тасралтгүй сайжруулахыг зорин ажиллаж байх.



Ач холбогдол

12

Байгууллагын ажилтан, албан хаагчдын ур чадвар болон чадамж нэмэгдэж, ажлын байрны орчин сайжирсан.

Дутагдаж буй ур чадварыг илрүүлж, удирдлагын дэмжиж туслах, тэдний ур чадварыг хөгжүүлэхийг уриалдаг болсон

Дээд албан тушаалтан нь албан хаагчидаа дэмжихэд нь туслах, урамшуулах тогтолцоо бий болсноор ажилчид ямар дэмжлэг авах боломжтой, түүнийг хэрхэн, хэзээ авах боломжтойг мэддэг болсон.

Албан хаагчдын санал хүсэлтийг тогтмол авдаг болсон төдийгүй удирдлага ба ажилчид хоорондын харилцаа холбоо сайжирснаар тус байгууллага нь зөрчилдөөнөөс зайлсхийж, эерэг зан төлөвийг бий болгосон.



Ач холбогдол

13

Өөрчлөлтийг хүлээн авах тал дээр тус байгууллага нь өөрчлөлтийн талаар албан хаагчдад нээлттэй зөвлөгөө өгөх, ажилтнуудад санал дэвшүүлэх боломжийг бий болгосон.

Мөн албан хаагчдад ажлын байранд гарсан аливаа өөрчлөлтийг хэрхэн хүлээн авах талаар сургалтыг явуулдаг болсон.



Resilience in Public Administration

14

Албан хаагчдын
resilience



Байгууллагын
resilience



ДҮГНЭЛТ

Монгол улсын хувьд resilience in public administration буюу төрийн удирдлагын үйл ажиллагааны уян хатан, эрсдэлд бэлэн байх, дасан зохицох цогц чадамж гэсэн ойлголт хараахан төлөвшиж амжаагүй байна гэж дүгнэж байна. Уг ойлголтыг төрийн байгууллага үйл ажиллагаандаа тусган олон улсын туршлагыг судлан өөрийн хөрсөнд буулгаж чадвал өнөөгийн нийгмийн олон олон асуудлуудыг олж харан шийдвэрлэж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, асуудал гарсан тохиолдолд даруй арга хэмжээ аван ажиллаж төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах боломжтой юм.



Ашигласан материал

16

- Working Well - An organizational approach to preventing psychological injury report
- <https://www.comcare.gov.au/>
- <https://dictionary.cambridge.org/dictionary/english/resilience>
- <https://www.anzam.org/> “Building resilient public sectors: How experiences of paradoxical leadership affect employee resilience”
- <https://montsame.mn/>



Анхаарал хандуулсанд баярлалаа